



Г ЧОЙБАЛСАН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДАРГА П.АМГАЛАНБААТАР ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.19 № 596
танай 2024.07.16 -ны № - -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Чойбалсан сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Чойбалсан сумын Монгол ардын намын Чойбалсан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Чойбалсан сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр 1 хуудас хавсаргав.

Хувийг: "Чойбалсан сумын Монгол ардын намын хороо"-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



Дорнод аймгийн Чойбалсан сумын
МАН-ын тэргүүлэгчдийн 2024 оны 07 сарын 17-ны өдрийн
01 дүгээр тогтоолын хавсралт

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Монгол ардын намын хорооны 2024
оны аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр**

- Монгол улсын хошой баатар маршал Х.Чойбалсангийн мэндэлсэн 130 жилийн ойг тохиолдуулан төрсөн газарт нь хүндэтгэлийн цогцолбор барина.
- Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны инженерийн байгууламж барина.
- Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц ашиглалтанд орно.
- Сумын төвд нийтийн ариун цэврийн байгууламж барина.
- Хавирга хилийн боомтын үйлчилгээний газруудад ариун цэврийн байгууламж барина.
- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхийг дэмжинэ.
- Аймгийн төвөөс Хавирга боомтын чиглэлд явж байгаа замыг Чойбалсан сумтай холбох 8км-тай, зураг төсвийг хийлгэж, замын ажлыг эхлүүлнэ.
- Сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- Айл өрх бүрийг гудамж талбайгаар нь өнгө үзэмж сайтай хашаагаар ижилсүүлнэ.
- Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөнө.
- “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг дэмжиж, үйл ажиллагааг тогтвортжуулна.
- “Хүндэтгэлийн өргөө”-тэй болох
- Сумын төвийн төвлөрсөн цэгүүдийг ундын усаар хангах
- Хөдөөгийн алслагдсан багт үүрэн телефоны сүлжээг нэмэгдүүлж, интернеттэй болгоно.
- Ахуй үйлчилгээний төвтэй болно.
- Сумын хэрэгцээнд туулах чадвартай авто машинтай болгоно.
- Биеийн тамир, спортын стандарт шаардлага хангасан заалтай болно.



2117144066
ХТҮ4037 9030891